# ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2013 оны 03 дугаар сарын 13-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: Компьютер болон хэвлэх төхөөрөмж нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар: PC-2013/01

Монголбанк нь эрх бүхий тендерт оролцогчоос ажлын хэрэгцээнд зориулан компьютер болон хэвлэх төхөөрөмж нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Тендер нь дараах багцтай байна. Үүнд:
Багц 1.Ширээний компьютер,
Багц 2.Зөөврийн компьютер,
Багц 3.Хэвлэх төхөөрөмж /принтер/.

Тендерийн бичиг баримтыг бичгээр хvсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгvй нөхцөлтэйгээр иж бvрдэл бvрийг нь 50,000 (тавин мянган) төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 6115000100 тоот дансанд тушаана. Тендер нь тvvнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хvчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:
Борлуулалтын хэмжээ: 250,000,000.00 төгрөг,
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 250,000,000.00 төгрөг,
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2012, 2011 он.
Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгож байгаа үнийн дүнгийн 2 (хоёр) хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн дvнтэй тендерийн баталгаа ирvvлнэ. Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй.

Тендерийг 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирvvлэх ба нээлтэд оролцох хvсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2013 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн бичиг баримт болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**МОНГОЛБАНК**

***Бага тойруу 3, 15160, Улаанбаатар хот,***

***Монголбанкны “А” байрны 1 давхар 2 тоот өрөө,***

***Утас: (976) 11-310633, 310150, Факс: (976)-11-311471***